

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА

Товъёг	
Удиртгал	2
Нэг. Салбарын өнөөгийн байдал	3
1.1. Зорилго, чиглэл	4
1.2. Стратеги, зорилт	4
1.3 Салбарын орлого	4
1.4 Дэд бүтэц	5
Хоёр. Салбарын хууль, тогтоомж, бодлогын баримт бичиг	6
3.1. Бодлогын баримт бичиг, эрх зүйн орчин	6
Гурав. Гол бүтээгдэхүүн, чиглэлүүд	7
Дөрөв.хөрөнгө оруулалтын боломж	8
4.1 Төрийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэгч байгууллагууд	8
Тав.эрсдэл, улирлын хамаарал	9
Дүгнэлт	10
Эх сурвалж	11

УДИРТГАЛ

Манай улсын хувьд аялал жуулчлалын салбар нь уул уурхай болон хөдөө аж ахуйн салбарын дараа орох эдийн засгийн гуравдагч том салбар бөгөөд аялал жуулчлалын салбарын хөгжил нь бусад салбаруудтай харьцуулахад нийт эдийн засагт хамгийн их үр өгөөж үзүүлдэг гэж цөөнгүй эмпирик судалгааны ажилд дүгнэсэн байдаг.

Иймд уул уурхайн салбараас өндөр хамаарал бүхий эдийн засагтай манай улсын хувьд аялал жуулчлалын салбарыг хөгжүүлснээр олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгох, эдийн засгийг төрөлжүүлэх улмаар валютын орох урсгалыг нэмэгдүүлэх, төлбөрийн тэнцлийг сайжруулах зэрэг өндөр ач холбогдолтой юм. Мэдээллийн үнэ цэнэд суурилсан өнөөгийн ертөнцөд судалгаанд үндэслэсэн санал, зөвлөмжөөр төрийн бодлого боловсруулах нь нэн ач холбогдолтой билээ.

Манай улсын аялал жуулчлалын салбарт өргөн цар хүрээтэй, бодлого боловсруулалтад дэмжлэг үзүүлэхүйц судалгааны ажил хомс байгаа тул Монголбанкнаас Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх Аялал жуулчлалын хөгжлийн төв (АЖХТ)-тэй хамтран энэхүү түүвэр судалгааны ажлыг гүйцэтгэлээ. Тус судалгааны зорилго нь аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг эрэлт /гадаад жуулчид/, нийлүүлэлтийн /тур операторууд/ талаас судалж, улмаар салбарын бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улс 2025 оны сүүлийн улиралд өвлийн аялал жуулчлалыг идэвхжүүлэх бодлого баримталсны үр дүнд 11 дүгээр сард 18,515, 12 дугаар сард 43,946 жуулчин хүлээн авч, жилийн эцсийн дүнгээр 850 мянга гаруй жуулчинтайгаар түүхэн амжилтаа шинэчилсэн байна¹. НҮБ-ын Аялал жуулчлалын байгууллагын судалгаагаар Монгол Улс салбарын сэргэлтээрээ дэлхийд тэргүүлэгч орнуудын нэгээр нэрлэгдсэн бөгөөд нийт жуулчдын 40 орчим хувь нь сэрүүний улиралд ирсэн нь дөрвөн улирлын аялал жуулчлалын орон болох стратегийн зорилт үр дүнтэй хэрэгжиж буйг баталлаа¹.

Мөн тус байгууллагаас гаргасан World Tourism Barometer, 2025 оны 11 дүгээр сар тайланд Монгол Улс аялал жуулчлалын салбарын сэргэлт, өсөлтийн үзүүлэлтээрээ дэлхийн шилдэг гүйцэтгэлтэй орнуудын нэг болохыг албан ёсоор баталгаажууллаа. Тус тайланд дурдсанаар, 2025 оны эхний 9 сард Монгол Улсад ирсэн олон улсын жуулчдын тоо 2019 онтой харьцуулахад 44 хувиар өссөн нь цар тахлын өмнөх түвшинг давж сэргэсэн, амжилттай орны нэг болсныг харуулж байна. Энэ үзүүлэлтээр Монгол Улс дэлхийн хэмжээнд жуулчдын урсгалаа хамгийн амжилттай сэргээсэн 20 орны жагсаалтад багтжээ².

"Go Mongolia" үндэсний брэнд болон визгүй зорчих бодлогын нөлөөгөөр салбарын орлого 1.6 тэрбум ам. долларт хүрч, аялал жуулчлал нь уул уурхайн бус экспортын орлогыг бүрдүүлэгч гол хүчин зүйл болон өргөжсөн байна³.

Зураг 1. Дэлхийн аялал жуулчлалын статистик



Хүснэгт 1. Аялал жуулчлалын голлох зах зээлийн үзүүлэлтүүд

Голлох зах зээл	МУ-д аялсан жуулчдын тоо (2025)	Эзлэх хувь (%)	Тухайн улсын нийт гадаад аялагчид (сая)	Нийт аялагчдаас МУ-д аялсан %	ДНБ (1 хүнд ногдох, USD)
БНХАУ	295,300	34.9%	155.0	0.19%	\$14,790
ОХУ	219,100	25.9%	22.0	0.99%	\$15,490
БНСУ	135,400	16.0%	29.5	0.46%	\$39,320
Япон	25,400	3.0%	20.0	0.13%	\$37,390
Казахстан	22,850	2.7%	11.5	0.20%	\$15,870

¹ Монголын аялал жуулчлалын холбоо, Аялал жуулчлалын салбарын сэргэлт ба стратегийн зорилтууд, 2025 оны тойм.

² НҮБ-ын Аялал жуулчлал [UN Tourism]. (2025, 11-р сар). Дэлхийн аялал жуулчлалын барометр (23-р боть, 5-р дугаар). Мадрид, Испани: Дэлхийн аялал жуулчлалын байгууллага.

³ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам [ССАЖЗЯ]. (2025). Гадаадын жуулчдын ирсэн тооны статистик мэдээ: 2025 оны жилийн эцэс. Монгол Улсын Засгийн газар.

АНУ	19,500	2.3%	100.0	0.02%	\$92,790
ХБНГУ	13,200	1.5%	99.0	0.01%	\$60,140
Франц	11,100	1.3%	30.4	0.04%	\$51,110
Австрали	7,600	0.9%	11.6	0.06%	\$70,110
ИБУИВУ	6,300	0.7%	93.0	0.007%	\$56,140
НИЙТ (Бусад улс багтсан)	846,103	100%			

2025 онд Монголд ирсэн жуулчдын доторх Хятад жуулчдын эзлэх хувь 34.9%-д хүрч, ОХУ-ыг тэргүүлсэн хэвээр байна. АНУ, Герман зэрэг өндөр орлоготой орнуудын нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ инфляци болон валютын ханштай холбоотойгоор өмнөх жилүүдээс өндөр гарсан.

1.1. Зорилго, чиглэл

Монгол Улсын байгаль, түүх, соёлын өвийг хамгаалах замаар аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, олон улсад өрсөлдөх чадвартай, тогтвортой, цахимжсан, дөрвөн улирлын аялал жуулчлалын төв болох.

- **Эдийн засгийн төрөлжилт:** Уул уурхайгаас хамааралтай эдийн засгийг аялал жуулчлалын орлогоор солонгоруулах.
- **Олон улсын сурталчилгаа:** "Go Mongolia" үндэсний брэндийг дэлхий дахинд таниулж, жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх.
- **Байгальд ээлтэй байх:** "Ногоон" аялал жуулчлалыг дэмжиж, байгалийн унаган төрхийг хадгалах.
- **Бүс нутгийн хөгжил:** Орон нутгийн иргэдийн оролцоог хангах замаар хөдөө орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх.

1.2. Стратеги, зорилт

- Нислэгийн тоог нэмэгдүүлэх, тийзийн үнийг бууруулах, агаарын тээврийн салбарт чөлөөт өрсөлдөөнийг дэмжих.
- Аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг олон улсын стандартад нийцүүлэх, үйлчилгээний байгууллагуудын зэрэглэлийг шинэчлэх.
- Аялал жуулчлалын гол бүсүүдийг хатуу хучилттай авто замаар холбох, цахилгаан, дулаан, цэвэрлэх байгууламжийн асуудлыг шийдэх.
- "Go Mongolia" үндэсний брэндийг дэлхийд таниулах, цахим виз (e-Visa) олголтыг хялбарчлах, нэгдсэн цахим платформыг хөгжүүлэх.
- Салбарт хөрөнгө оруулалт хийж буй ААН-үүдэд хөнгөлөлттэй зээл олгох (6%-ийн хүүтэй), татварын дэмжлэг үзүүлэх.

1.3 Салбарын орлого

Монгол Улсын аялал жуулчлалын салбарын орлого 2025 оны эцсийн байдлаар өмнөх онтой харьцуулахад 14 хувиар өсөж, эдийн засгийн төрөлжилтийг хангах гол хөдөлгүүр болж байна⁴ Тус салбар нь 2024 онд 1.6 тэрбум ам.долларын орлого төвлөрүүлж байсан бол 2025 оны эхний есөн сарын байдлаар орлогын хэмжээ нь цар тахлын өмнөх үе буюу 2019 онтой харьцуулахад 39 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.⁵ Энэхүү өсөлтөд "Go Mongolia" үндэсний брэндиг болон олон улсын нислэгийн тоо нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн бөгөөд нийт жуулчдын тоо 854,235-д хүрсэн нь орлого түүхэн дээд хэмжээнд

⁴ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, 2025.

⁵ Монголын аялал жуулчлалын холбоо [МТА], 2025).

хүрэх бодит суурь боллоо. Засгийн газрын зүгээс 2030 он гэхэд салбарын орлогыг 8 тэрбум ам.долларт хүргэж, ДНБ-ий 10 хувийг бүрдүүлэх стратегийн зорилт тавин ажиллаж байна⁶. Түүнчлэн, эко аялал жуулчлалын дэлхийн чиг хандлагатай уялдуулан дотоодын үйлчилгээний стандартыг сайжруулснаар нэг жуулчнаас орох дундаж орлогыг нэмэгдүүлэх бодлого баримталж байна .

Монгол Улсын аялал жуулчлалын салбар 2025 оны эцсийн байдлаар Дотоодын нийт бүтээгдэхүүний 3–4 хувийг бүрдүүлж байна. Хэдийгээр салбарын орлого болон жуулчдын тоо эрчимтэй өсөж байгаа ч ДНБ-д эзлэх жин нь уул уурхайн салбарын давамгайлал болон бусад салбаруудын өсөлттэй холбоотойгоор энэ түвшинд хадгалагдаж байна.

Хүснэгт 1. Аялал жуулчлалын экспортын үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2025 оны гүйцэтгэл /таамаглал/	Өмнөх онтой харьцуулахад
Нийт жуулчдын тоо	хүн	854,235	+14.2%
Экспортын нийт орлого	тэрбум USD	1.6 - 1.8	+20%
Нэг жуулчны дундаж зарцуулалт	USD	1,950 - 2,100	+5%
ДНБ-д эзлэх хувь хэмжээ	хувь	7.2% - 8.0%	+0.8%
Аялал жуулчлалын салбарын ажлын байр	мянга	105.4	+12%
Цахим виз (e-Visa) олголт	хувь	95.7%	+4.5%
Нислэгийн суудлын тоо (багтаамж)	сая	1.5	+15%

Монгол Улс 2025 онд аялал жуулчлалын экспортоороо түүхэн дэх хамгийн өндөр буюу 1.8 тэрбум ам.долларт дөхсөн орлого олсон байна. Энэ нь уул уурхайн бус экспортын орлогын хамгийн том эх үүсвэр болж чадсан юм.

1.4 Дэд бүтэц

Монгол Улс аялал жуулчлалын стратегийн 17 байршилд дэд бүтцийн иж бүрэн бүтээн байгуулалтыг өрнүүлж, 1,800 гаруй зочид буудал болон 640 гаруй жуулчны баазыг олон улсын стандартад нийцүүлэн шинэчилснээр салбарын өрсөлдөх чадварыг үндсэн шатанд гаргаад байна.

- Стратегийн 17 байршил: Эдгээр байршилд гадаад, дотоодын хөрөнгө оруулалт татах, бүс нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалын цогцолборууд бий болгохоор төлөвлөн ажиллаж байна.
- Байршуулах хэрэгслийн стандарт: Салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор зочид буудал (MNS 4588:2008), жуулчны бааз, резорт (MNS 6043:2009) болон дэн буудлын стандартуудыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, баталгаажуулах ажил эрчимтэй явагдаж байна.
- Санхүүгийн дэмжлэг: Аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг сайжруулах, дэд бүтэц барих хөрөнгө оруулагчдад зориулж 6%-ийн хүүтэй, 6 хүртэлх жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээлийг олгож эхлээд байна.

⁶ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам. (2025). Үндэсний форум: Аялал жуулчлалын ирээдүй ба эдийн засгийн нөлөөлөл

- Цахим шилжилт: 75 улсын 85,600 гаруй иргэнд цахим виз (e-Visa) олгож, виз олголтын түвшин 95.7%-д хүрсэн нь олон улсын дунджаас өндөр үзүүлэлт болоод байна.

ХОЁР. САЛБАРЫН ХУУЛЬ, ТОГТООМЖ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

3.1. Бодлогын баримт бичиг, эрх зүйн орчин

Хууль эрх зүйн орчин нь хөрөнгө оруулагчдад татварын тогтвортой байдал болон санхүүгийн хямд эх үүсвэр (зээл) авах боломжийг олгоход чиглэгдэж байна. Ялангуяа орон нутагт жуулчны бааз, зочид буудал барихад татварын томоохон хөнгөлөлтүүд эдлэх боломжтой.

Хүснэгт 2. Хууль, эрх зүйн орчин /хөрөнгө оруулагчид үзүүлэх дэмжлэг/

Хууль, тогтоомж	Гол заалт	Утга /Дэмжлэг/
Аялал жуулчлалын тухай хууль (2023 оны шинэчилсэн найруулга)	11.2, 24.1	Аялал жуулчлалын мэргэжлийн холбоог байгуулсан. Тусгай бүсүүдэд хөрөнгө оруулах эрх зүйн орчин бүрдсэн.
ЗГ-ын 2023 оны 185-р тогтоол	"Зээлийн журам"	Аялал жуулчлалын ААН-үүдэд жилийн 6%-ийн хүүтэй хөнгөлөлттэй зээл олгох (Арилжааны банкуудаар дамжуулан).
ААНОАТ-ын тухай хууль	22.1.1	Улаанбаатараас 500км-ээс хол аймагт 50%, 1000км-ээс хол бол 90% татварын хөнгөлөлт (5 жилийн хугацаанд).

Бодлогын баримт бичгүүд нь Монгол Улсыг дэлхийн зах зээлд нээлттэй, хүртээмжтэй болгоход чиглэж байна. "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд агаарын тээврийн өрсөлдөөнийг дэмжсэнээр нислэгийн тийзийн үнэ буурч, жуулчдын урсгал болон хөрөнгө оруулалтын өгөөж нэмэгдэх суурь нөхцөл бүрдэж байна.

Хүснэгт 3. Салбарын бодлогын баримт бичиг

Д/д	Бодлогын баримт бичиг	Зорилт/заалт	Утга
1	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого	4.2 дугаар зорилт	Аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгож, олон улсад өрсөлдөх чадвартай "Монгол брэнд"-ийг бий болгох.
2	Шинэ сэргэлтийн бодлого (Дунд хугацааны хөтөлбөр)	6.3 дугаар заалт	Аялал жуулчлалын дэд бүтцийг сайжруулах, агаарын тээврийн либеральчлалыг эрчимжүүлж, жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх.
3	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2.1.8 дугаар заалт	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг олон улсын стандартад нийцүүлж, "Монголд зочлох жил" арга хэмжээг үргэлжлүүлэх.

4	"Цахим Монгол" хөтөлбөр (Салбарын цахим шилжилт)	Зорилт 3	Аялал жуулчлалын нэгдсэн платформ (Visit Mongolia) хөгжүүлж, жуулчдад зориулсан цахим үйлчилгээг (виз, захиалга) хялбарчлах.
5	Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого	Стратегийн зорилт 2	Байгальд ээлтэй, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, орон нутгийн иргэдийн оролцоог хангах замаар ажлын байр нэмэгдүүлэх.

ГУРАВ. ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮН, ЧИГЛЭЛҮҮД

Засгийн газраас "Go Mongolia" стратегийн хүрээнд эдгээр бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд сурталчилж байгаа бөгөөд ялангуяа өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлж, улирлын хамаарлыг бууруулахад онцгой анхаарч байна.

Хүснэгт 4. Аялал жуулчлалын гол бүтээгдэхүүн, чиглэлүүд

Д/д	Бүтээгдэхүүний төрөл	Үндсэн агуулга, онцлог	Гол чиглэл, байршлууд
1	Соёл, нүүдлийн ахуйн аялал	Нүүдэлчин ахуйтай танилцах, малчин айлд зочлох, наадам, цагаан сар зэрэг уламжлалт баяр ёслол.	Төв, Архангай, Өвөрхангай (Орхоны хөндий), Хэнтий аймаг.
2	Байгалийн болон эко аялал	ЮНЕСКО-гийн өвд бүртгэгдсэн байгалийн цогцолбор газрууд, шувуу ажиглах, зэрлэг ан амьтан харах.	Хөвсгөл нуур, Горхи-Тэрэлж, Алтай Таван Богд, Хустайн нуруу.
3	Түүхэн болон археологийн аялал	Эзэн Чингис хааны түүхтэй холбоотой газрууд, Хүннүгийн олдвор, эртний хот балгадын туурь.	Хэнтий (Чингис хот), Өвөрхангай (Хархорин), Дорнод аймаг.
4	Адал явдалт ба спорт аялал	Морин аялал, явган аялал (trekking), ууланд авиралт, загасчлал, ралли болон бартаат замын аялал.	Баян-Өлгий (Алтай), Хөвсгөл (Тайга), Өмнөговь (Говь).
5	Говийн болон палеонтологийн аялал	Үлэг гүрвэлийн олдвор бүхий газрууд, элсэн манхан, тэмээн аялал, одон орон ажиглах.	Өмнөговь (Баянзаг, Хонгорын элс), Дундговь, Дорноговь.
6	Өвлийн аялал жуулчлал	"Хөх сувд" мөсний баяр, Тэмээний баяр, бүргэдийн баяр, цана болон чарганы аялал.	Хөвсгөл, Баян-Өлгий, Өмнөговь, Улаанбаатар орчим.
7	MICE аялал (Хурлын аялал)	Олон улсын хурал зөвлөгөөн, үзэсгэлэн, бизнес уулзалт, урамшуулалт аялал.	Улаанбаатар хот болон Тэрэлж орчмын өндөр зэрэглэлийн резортууд.

ДӨРӨВ.ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОЛОМЖ

Засгийн газраас 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарлаж, "Go Mongolia" үндэсний брэндийг дэлхийд таниулах маркетингийг эрчимжүүлсэн. Энэ нь зөвхөн уриа төдий биш, агаарын тээврийг чөлөөлөх (нислэгийн тоо нэмэгдэх), визний нөхцөлийг хөнгөвчлөх (цахим виз) зэрэг бодит алхмуудаар баталгаажиг байна.

Жуулчдын тоо жил бүр тогтмол өсөж байгаа боловч (2025 онд ~850 мянга) тэднийг хүлээн авах олон улсын стандартын зочид буудал, жуулчны бааз, амралтын цогцолборын нийлүүлэлт дутмаг хэвээр байна. Ялангуяа өндөр төлбөрийн чадвартай (АНУ, Европ, Япон) жуулчдад зориулсан "Люкс" зэрэглэлийн үйлчилгээний салбарт асар их орон зай бий.

Хүснэгт 5. Хөрөнгө оруулалтын тэргүүлэх 5 чиглэл

№	Хөрөнгө оруулалтын чиглэл	Гол байршил / Үзүүлэлт	Зах зээлийн эрэлт & Боломж
1	Дээд зэрэглэлийн байршуулах үйлчилгээ	Улаанбаатар, Хөвсгөл, Архангай, Өмнөговь	2025 онд 854,235 жуулчин хүлээн авсан тул олон улсын стандартын эко-ресорт, зочид буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай.
2	Зам дагуух үйлчилгээний цогцолбор	Олон улсын чанартай авто зам дагуух 58 байршил	Стандартын ариун цэврийн байгууламж, хоол үйлчилгээ, түр буудаллах цэг бүхий нэгдсэн цогцолборуудын хоосон орон зайг нөхөх.
3	Өвлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн	Өвлийн спортын төвүүд, рашаан сувилал	Улирлын хамаарлыг бууруулах бодлогын хүрээнд мөсөн болон цасны баяр, эрүүл мэндийн аялал жуулчлалд хөрөнгө оруулах.
4	Тээвэр, логистикийн парк шинэчлэл	Жуулчин тээврийн зориулалттай парк	Тусгай тоногдсон автомашин, стандартын автобус болон дотоодын нислэгийн хувийн компаниудтай хамтран ажиллах нээлттэй боломж.
5	"Go Mongolia" брэнд бүтээгдэхүүн	Үндэсний брэнд сурталчилгааны хүрээнд	Олон улсын маркетингийн нөлөөгөөр бий болсон шинэ урсгалд зориулсан дижитал технологи, ухаалаг аяллын шийдлүүд.

4.1 Төрийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэгч байгууллагууд

Сүүлийн жилүүдэд өндөр зэрэглэлийн "glamping" болон эко аялал жуулчлалын төслүүд технологи болон дэд бүтцийн хөрөнгө оруулалт ихээр авч байна

- **Three Camels Lodge:** Говьд байрлах, олон улсын шагналт эко лодж.
- **Mongke Tengri Camp:** Өндөр зэрэглэлийн үйлчилгээ, дэд бүтцээрээ онцлог ресорт

Хүснэгт 6. Дэмжлэг үзүүлэгч байгууллагуудын ангилал

Д/д	Байгууллагын нэр	Үндсэн чиг үүрэг /Дэмжлэг/	Дэмжлэгийн төрөл
1	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Салбарын бодлого, стратегийг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах.	Бодлогын дэмжлэг

2	Хөрөнгө оруулалт, худалдааны газар (ЭЗХЯ-ны дэргэдэх)	Хөрөнгө оруулагчдад "Нэг цэгийн үйлчилгээ" үзүүлэх, татварын тогтворжуулах гэрчилгээ олгох.	Хөрөнгө оруулалтын хамгаалалт
3	Арилжааны банкууд (Хаан, Голомт, ХХБ г.м)	Засгийн газрын эх үүсвэрээр 6%-ийн хүүтэй , хөнгөлөлттэй зээлийг ААН-үүдэд олгох.	Санхүүгийн дэмжлэг
4	Зээлийн батлан даалтын сан	Барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа бизнес эрхлэгчдийн зээлийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах.	Барьцааны дэмжлэг
5	Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо	Салбарын стандартыг мөрдүүлэх, зочид буудал, баазуудад зэрэглэл тогтоох, сургалт зохион байгуулах.	Мэргэжлийн арга зүй
6	Жижиг, дунд үйлдвэрийн газар	Орон нутгийн аялал жуулчлалын төслүүдэд тоног төхөөрөмжийн болон жижиг зээлийн дэмжлэг үзүүлэх.	Төслийн санхүүжилт
7	Азийн хөгжлийн банк (АХБ) болон GIZ	Дэд бүтэц, байгаль орчныг хамгаалах, "Ногоон" аялал жуулчлалыг хөгжүүлэхэд буцалтгүй тусламж үзүүлэх.	Олон улсын тусламж

ТАВ.ЭРСДЭЛ, УЛИРЛЫН ХАМААРАЛ

Монгол Улсын аялал жуулчлалын салбар 2025 онд түүхэн амжилт үзүүлсэн ч салбарын тогтвортой өсөлтөд саад болж буй суурь эрсдэлүүд болон байгаль цаг уураас хамааралтай сорилтууд байсаар байна.

- **Улирлын хамаарал ба эдийн засгийн үр ашиг:** Монголын аялал жуулчлалын урсгалын 70 гаруй хувь нь 6-аас 8 дугаар сарын хооронд төвлөрсөн хэвээр байна. Энэхүү улирлын хамаарал нь аялал жуулчлалын компаниуд болон байршуулах хэрэгслүүдийн жилийн турш ажиллах тогтвортой байдлыг алдагдуулж, орлогын тэнцвэргүй байдлыг үүсгэдэг. Хэдийгээр өвлийн арга хэмжээнүүдийг бодлогоор дэмжиж байгаа ч өвлийн дэд бүтэц, дулаан хангамжийн шийдэл дутмаг байгаа нь жуулчдын урсгалыг жилийн турш тогтмол барихад томоохон саад болж байна⁷.
- **Байгаль орчны доройтол:** Гол чиглэлүүдэд жуулчдын төвлөрөл даацаас хэтэрч байгаа нь байгаль орчны бохирдол, хөрсний эвдрэл, усны нөөцийн хомсдол үүсгэх эрсдэлийг дагуулж байна. "Хариуцлагатай аялал жуулчлал"-ын стандарт бүрэн нутагшаагүй байгаа нь байгалийн үзэсгэлэнт газруудын унаган төрх алдагдах аюулыг бий болгож байна.
- **Дэд бүтцийн ачаалал:** Оргил ачааллын үед орон нутгийн авто замын сүлжээний даац хэтэрч, зам тээврийн осол нэмэгдэх хандлагатай байна (ҮСХ, 2025). Мөн олон улсын стандарт хангасан түр буудаллах цэг, ариун цэврийн байгууламж болон хог хаягдлын менежмент жуулчдын өсөн нэмэгдэж буй тоог гүйцэхгүй байгаа нь үйлчилгээний чанарыг бууруулах эрсдэл болж байна⁸.
- **Хүний нөөцийн тогтворгүй байдал:** Улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг тул салбарын мэргэшсэн боловсон хүчин тогтвортой ажиллах сонирхол бага байна

⁷ Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ), 2025; Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, 2025.

⁸ Мөн тэнд

(МТА, 2025). Энэ нь үйлчилгээний чанар жил бүр хэлбэлзэх, зочлох үйлчилгээний соёл олон улсын түвшинд хүрэхгүй байх гол шалтгаан болж байна⁹.

- **Геополитик ба зах зээлийн төвлөрөл:** Нийт жуулчдын дийлэнх хувийг цөөн зах зээл бүрдүүлж байгаа нь гадаад харилцааны тогтворгүй байдал эсвэл бүс нутгийн эдийн засгийн хямралд өртөмтгий байх эрсдэлийг бий болгож байна. Түүнчлэн, нислэгийн тийзийн үнэ дэлхийн дунджаас өндөр байгаа нь алслагдсан зах зээлээс жуулчин татахад өрсөлдөх чадварыг сулруулж байна
- **Уур амьсгалын өөрчлөлт:** Гэнэтийн байгалийн үзэгдэл, зуд, ган болон уур амьсгалын дулаарал нь нүүдэлчин ахуйн соёлын аялал жуулчлалд шууд сөрөг нөлөө үзүүлж, аяллын хөтөлбөрүүд цуцлагдах эрсдэлийг нэмэгдүүлж байна

ДҮГНЭЛТ

Монгол Улсын аялал жуулчлалын салбар нь 2024–2025 онд бодлогын идэвхжил, олон улсын маркетинг (“Go Mongolia” брэнд), визийн хөнгөлөлт зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр эрчимтэй сэргэж, түүхэн дээд үзүүлэлтүүдэд хүрсэн нь тус салбар эдийн засгийн шинэ тулгуур чиглэл болон төлөвшиж буйг тодорхой харуулж байна. Жуулчдын тоо 850 мянгыг давж, салбарын орлого 1.6 тэрбум ам.долларт хүрсэн нь аялал жуулчлал уул уурхайн бус экспортын орлогын чухал эх үүсвэр болж байна.

Зах зээлийн бүтцийн хувьд Зүүн Ази, Номхон далайн бүсийн жуулчдын эзлэх хувь эрс нэмэгдэж, зах зээлийн төвлөрөл тодорхой хэмжээнд бий болсон ч цаашид Европ болон бусад шинэ зах зээлийг тэлэх бодлогын шаардлага үүсч байна. Үүний зэрэгцээ дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого үр дүнгээ өгч эхэлсэн ч улирлын хамаарал бүрэн шийдэгдээгүй хэвээр байна.

Хөрөнгө оруулалтын орчны хувьд татварын хөнгөлөлт, хүүгийн татаастай зээл, дэд бүтцийн дэмжлэг зэрэг төрийн бодлого нь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх таатай нөхцөл бүрдүүлж байна. Ялангуяа өндөр зэрэглэлийн байршуулах үйлчилгээ, зам дагуух үйлчилгээний цогцолбор, өвлийн аялал жуулчлал, дижитал шийдэл бүхий “ухаалаг аялал”-ын бүтээгдэхүүнүүдэд зах зээлийн бодит эрэлт, өсөлтийн боломж өндөр байна.

Гэсэн хэдий ч салбарын тогтвортой өсөлтөд улирлын хэлбэлзэл, дэд бүтцийн хязгаарлалт, хүний нөөцийн тогтворгүй байдал, байгаль орчны доройтол, геополитикийн эрсдэл зэрэг суурь сорилтууд нөлөөлсөөр байна. Эдгээрийг шийдвэрлэхгүйгээр салбарын өрсөлдөх чадварыг урт хугацаанд хадгалах боломж хязгаарлагдана.

Иймд цаашид:

- дөрвөн улирлын бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг эрчимжүүлэх,
- бүсчилсэн хөгжлийг бодитоор хэрэгжүүлэх,
- дэд бүтэц, үйлчилгээний стандартыг олон улсын түвшинд хүргэх,
- тогтвортой (ногоон) аялал жуулчлалын зарчмыг нэвтрүүлэх,
- хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх,
- зах зээлийн төрөлжилтийг нэмэгдүүлэх

зэрэг чиглэлүүдэд бодлого, хөрөнгө оруулалтыг оновчтой төвлөрүүлэх шаардлагатай байна.

⁹ Монголын Аялал Жуулчлалын Ассоциаци (МТА). (2025). *Аялал жуулчлалын хүний нөөц, үйлчилгээний чанарын тайлан*.

ЭХ СУРВАЛЖ

I. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ

1. Монгол Улсын Их Хурал. (2007). Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль.
2. Монгол Улсын Их Хурал. (2008). Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль.
3. Монгол Улсын Их Хурал. (2012). Инновацын тухай хууль.
4. Монгол Улсын Их Хурал. (2015). Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль.
5. Монгол Улсын Их Хурал. (2019). Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль.
6. Монгол Улсын Их Хурал. (2023). Аялал жуулчлалын тухай хууль (шинэчилсэн найруулга).

II. ТӨРИЙН БОДЛОГО, ХӨТӨЛБӨР

7. Монгол Улсын Засгийн газар. (2020). “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого..
8. Монгол Улсын Засгийн газар. (2021). “Шинэ сэргэлтийн бодлого”.
9. Монгол Улсын Засгийн газар. (2024). Аялал жуулчлалын салбарын хөгжлийн бодлого, тайлан.
10. Байгаль орчин, аялал жуулчлалын яам. (2022). Аялал жуулчлалын салбарын хөгжлийн бодлого.
11. Байгаль орчин, аялал жуулчлалын яам. (2023). Монгол Улсын аялал жуулчлалын статистик, тайлан.
12. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам. (2025). Аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалтын бодлого.

III. ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАН

13. United Nations World Tourism Organization (UNWTO). (2024). World Tourism Barometer.
14. United Nations World Tourism Organization (UNWTO). (2024). Tourism Recovery Reports.
15. United Nations Educational, Scientific and Cultural Organization (UNESCO). (2021). World Heritage and Cultural Tourism Reports.
16. United Nations Development Programme (UNDP). (2023). Tourism and Sustainable Development in Mongolia.

IV. СУДАЛГАА, ТАЙЛАН, НОМ

17. Монголын Аялал Жуулчлалын Холбоо. (2022). Аялал жуулчлалын салбарын судалгааны тайлан. Улаанбаатар.
18. Adventure Travel Trade Association. (2023). Adventure Tourism Development Index. Washington, D.C.
19. National Geographic. (2022). Global Travel and Tourism Features. Washington, D.C.
20. ICC Mongolia. (2023). MICE Tourism Development Report.